

**Мах, махан бүтээгдэхүүнийг авч оруулахгүй байх**

- Ихэнх улс орноос, хяналт шалгалтын бичиг баримтгүйгээр мах, хиам, зайдас, бекон зэрэг мах, махан бүтээгдэхүүнийг Япон улсын хилээр оруулахыг хориглоно.
- Бага оврын шуудангаар мах, махан төрлийн бүтээгдэхүүн зэргийг хийж явуулахгүй байхыг гэрийнхэн болон найз танилдаа дамжуулна уу.
- Бага оврын ачаа, шуудангаар хяналт шалгалтанд ороогүй мах, махан бүтээгдэхүүн хүлээн авсан тохиолдолд ойролцоох Мал эмнэлэг, хорио цээрийн хяналтын улсын албанд нэн даруй мэдэгдэнэ үү.

※импортын хяналт, шалгалт хийлгэлгүй малын гаралтай бүтээгдэхүүн авч орсон тохиолдолд, 3 жил хүртэлх хугацаагаар албадан хөдөлмөр эрхлүүлж хорих ял эсвэл 3 сая иен хүртэлх мөнгөн торгууль оногдуулна.(Аж ахуйн нэгж бол 50 сая хүртэлх иен)

**Ариутгал хийнэ!**

- Гадаадад байхдаа хэрэглэж бохирдсон ажлын хувцас, ажлын гутал, түрүүтэй гутал зэргийг битгий авч ирээрэй.
- Гадаадад байхдаа мал сүрэгтэй газар очсон болон японд мал амьтанд хүрэх төлөвлөгөөтэй байгаа хүн, хилээр орох үедээ гар тээшээ авах хэсэгт байгаа "Мал эмнэлэг, хорио цээрийн хяналтын лавлах"-д түр хүрч ирнэ үү.

**Гадаадад байхдаа мал, амьтанд хүрэхээс зайлсхийх**

- Япон улсад ирэхээс өмнөх 1 долоо хоногийн дотор, мал амьтанд хүрэхээс зайлсхийнэ үү.
- Японоос ирснээс хойшхи 1 долоо хоногт, мал амьтанд хүрэхээс зайлсхийнэ үү.

